

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн талаарх мэдээлэл	3
1.2. Зүүндалан, далангийн нүүрсний ордын нөөцийн тооцоо.....	7
1.3. Уурхайн ажиллах горим.....	9
1.4. Үйлдвэрлэлийн нөөц.....	9
1.5. Үйлдвэрлэлийн процессууд	10
1.6. Хөрс тээвэрлэх процесс	11
1.7. Нүүрс олборлолтын процесс.....	11
1.8. Уурхайн ажиллах хүчин чадал, хүний нөөц	16
1.9. Усан хангамж.....	19
1.10. Уурхайн ус таталт Нүүрст давхаргын шинж чанар	20
1.11. Уурхайг гадаргын уснаас хамгаалах ажил	21
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	25
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	26
БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	29
БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	30
БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	30
БҮЛЭГ 9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	30
БҮЛЭГ 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	31
БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	33
БҮЛЭГ 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	35
БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	37
БҮЛЭГ 14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ.....	38
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ ДҮГНЭЛТ	39

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн солбицол	3
Хүснэгт 2. Далан талбайд хамаарах нүүрсний нөөцийн нэгдсэн хүснэгт (Ордын нөөц 2020 оны 04-р сарын 01-ны байдлаар) /тусгай зөвшөөрлийн дугаар MV-021008/	7
Хүснэгт 3. Ил уурхайн уулын ажлын горим	9
Хүснэгт 4. Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо	9
Хүснэгт 5. “Зүүндалан, далан” уурхайн нүүрсний 2026 оны төлөвлөгөө.....	10
Хүснэгт 6. Уулын ажлын механикжуулалтын бүтэц.....	10
Хүснэгт 7. Хөрс хуулалтын хэмжээ	11
Хүснэгт 8. Хөрсний экскаваторын бүтээл.....	11
Хүснэгт 9. Хөрсний экскаваторын шаардлагатай тоо	11
Хүснэгт 10. Нүүрс олборлолтын хэмжээ.....	11
Хүснэгт 11. Нүүрсний экскаваторын бүтээл.....	12
Хүснэгт 12. Хөрсний мөргөцгийн тэсэлгээний параметр /2018 онд батлагдсан ТЭЗҮ- ийн дагуу үндсэн үзүүлэлтүүдийг авав. Цооногийн диаметрийг зэргэлдээх уурхайн үзүүлэлтээр сонгов./	17
Хүснэгт 13. Хөрсний мөргөцгийн тэсэлгээний ажлын тооцооны нэгдсэн үзүүлэлт	17
Хүснэгт 14. Тэсрэх бодис болон тэслэх хэрэгслийн зарцуулалт	19
Хүснэгт 15. Жилийн нийт цахилгааны хэрэглээ.....	19
Хүснэгт 16. 2026 оны усны хэрэглээ.....	19
Хүснэгт 17. Насос усны шахуургын үзүүлэлт.....	20
Хүснэгт 18. Нүүрсний дулаан гаргах чадварын үзүүлэлтүүд.....	20
Хүснэгт 19. Зумпфийн хэмжээ	20
Хүснэгт 20. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим.....	22
Хүснэгт 21. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	27
Хүснэгт 22. Техникийн нөхөн сэргээлтийн зардал.....	29
Хүснэгт 23. Дүйцүүлэн хамгаалах ажлын зардал	30
Хүснэгт 24. Суулгах модны хэмжээ, зардал.....	30
Хүснэгт 25. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	31
Хүснэгт 26. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	33
Хүснэгт 27. 2026 онд хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	35
Хүснэгт 28. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	37
Хүснэгт 29. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь, зардлын задаргаа.....	38
Хүснэгт 30. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт	41

Зургийн жагсаалт

Зураг 1. Талбайн байршил	4
Зураг 2. Уурхайн барилга байгууламж	15
Зураг 3. Засварын байр.....	16
Зураг 4. ШТС.....	16

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн талаарх мэдээлэл

Төслийн нэр: “Далан нүүрсний уурхай” Ил аргаар ашиглах

Төслийн зорилго: “Билэгт Баялаг” ХХК-ийн MV-021008 тусгай зөвшөөрөл бүхий Далангийн нүүрсний уурхайн 2022 онд ЭБМЗ-ийн хэлэлцүүлэн тодотгосон үлдэгдэл нөөцөд тулгуурлан техник эдийн засгийн үндэслэл журамд нийцүүлэн уг төслийг холбогдох татвар төлбөрийг улс, орон нутгийн төсөвт төлөх, тодорхой тооны ажлын байрыг хадгалах, байгаль орчныг нөхөн сэргээхэд энэхүү төслийн зорилго оршино.


Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Дорноговь аймаг, Даланжаргалан, 3-р баг Олон овоо, Харуул овоо, 13- 3 тоот, Улсын бүртгэлийн дугаар 9019085092, Регистрийн дугаар 5249088, Утас: 99999979

Төслийн байршил: “Билэгт баялаг” ХХК-ийн Далан нүүрсний уурхай төслийн тусгай зөвшөөрлийн талбай нь засаг захиргааны нэгжийн хуваариар Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт харьяалагдах бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 270 км, төмөр замын 25-р зөрлөг болон Улаанбаатар-Сайншандыг холбосон авто замаас 24 км, Даланжаргалан сумаас баруун хойш 28 км зайд байрлана. Зүүндалан, Далангийн нүүрсний ордын хойд хэсэг нь ашигт малтмал ашиглах MV-021008 тоот тусгай зөвшөөрөлтэй, 178.98 га талбайг хамардаг. Зүүндалан, Далангийн нүүрсний ордын хойд хэсгийн ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн солбицлын цэгүүдийг хүснэгт харуулав.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн солбицол

Цэгийн дугаар	Уртлаг			Өргөрөг		
	Град	Мин	Сек	Град	Мин	Сек
1	108	58	1.63	46	8	11.66
2	108	58	1.63	46	7	51.66
3	108	58	21.62	46	7	51.66
4	108	58	21.62	46	7	31.65
5	108	56	41.63	46	7	31.65
6	108	56	41.63	46	7	51.66
7	108	57	26.62	46	7	51.66
8	108	57	26.62	46	8	11.66

Зураг 1. Талбайн байршил



Зам харилцаа: Уурхайн карьер, хөрсний овоолго, кемп, засварын газрууд нь хоорондоо шороон замаар холбогдсон. Уурхайгаас нүүрс тээврийн зам хүртэлх замын даланг уурхайн хөрс хуулалтаас гарсан хөрсөөр хийсэн ба технологийн тээврийн зам нь 20 м өргөнтэй нийт 1.4 км замын суурь нь 0.45 м зузаан, 0,25 метр хайрган хучилттай бөгөөд цаг агаарын байдалд тэсвэртэй, ус урсах боломжтой 100 хүртэл тонны даацтай тээврийн хэрэгслүүд явахад зориулагдсан.

Физик газарзүй: Уурхайн талбай нь намхан толгод зонхилсон тал хээрийн бүсэд багтах бөгөөд хамгийн өндөр цэг нь уурхайн талбайгаас зүүн хойш 3.7 км-т байрлах 1352.2 тоот өндөрлөг бол нам доор цэг нь уурхайн талбайгаас баруун тийш 7 км-т байрлах Бэхтийн-Улаан нуур /1179.6 м/ юм. Харьцангуй өндөржилт нь 50 м-с хэтрэхгүй.

Байгаль цаг уурын нөхцөл: Ордын талбайн орчин тойрон нь эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай. Даланжаргалан сум болон түүний орчин тойрны цаг уурын элементүүдийн сүүлийн 10 жилийн ажиглалтын дунджаар 16.5 мм хур тунадас унах бөгөөд үүний ихэнх нь 4-10-н сарын хооронд унана. 7-р сард дулааны дундаж хэм +25 градус, 01 сард -23 градус хүрч хүйтрэнэ. Дулааны улиралд +10 градусаас дээш хугацааны нийлбэр 2000-2800 градус, ургамал ургалтын үе нь 120-130 хоног байдаг. Жилийн туршид гол төлөв баруун зүгийн салхи зонхилох ба 4, 5 саруудад салхины хүч эрчимждэг.

Хөрсөн бүрхэвч: БОНБНУ-ний хүрээнд хийгдсэн хээрийн судалгааны үр дүнд тус төслийн талбай орчим нь хөрс газарзүйн мужлалтын хувьд Хангайн их мужийн өргөрөгийн бүсшилттэй нутгийн Цайвархүрэн хөрсний дэд бүсийн хүрээнд Баяндэлгэрийн хөрсний тойрогт хамрагдаж байна. Төсөл хэрэгжиж буй бүс нутаг нь хуурай хээр, говийн бүсийн зааг толгодорхог ландшафт зонхилсон бөгөөд толгодын хэсгээр сайргархаг

цайвархүрэн хөрс, харьцангуй тэгшивтэр гадаргаар карбонаттай цайвархүрэн хөрс, хөндий хотгорын хэсгээр хужирлаг бараан, зузаан элсэнцэр цайвархүрэн хөрс тус тус тархсан.

Ургамлын аймаг: Төслийн талбай нь ургамлын мужлалаар Төв Азийн тал талархуу газрын ургамалжил бүхий Евразийн хээрийн их муж, хуурайдуу хэв шинжийн Алтанширээгийн тойрогт багтдаг ба газрын гадаргын хувьд цав толгод ухаа гүвээ, хотос хотгор, тойром бүхий гадарга зонхилох бөгөөд голлон тааралдах ургамлын хэв шинж нь бэсрэг уулсын налуу хажуу тал хөндийд крыловын хялгана-сөөгөнцөр, таана-сайрын хялгана, говийн хялгана-заримдаг сөөгөнцөр, дэрс бүхий таана-бударгана зэрэг цөлөрхөг хээрийн бүлгэмдэл зонхилсон байх бөгөөд элсэрхэг сайргархаг тэгш талархаг талаар Зүүнгарын улаанбударгана, сэдэргэнэ, таана зэрэг цөл хээрийн ургамалжилттай.

Гадаргын болон гүний ус: Ус зүйн хувьд Төв Азийн гадагш урсгалгүй ай савын бүсэд хамаарах бөгөөд гидрогеологийн мужлалаар улирлын хомс тэжээлтэй мужид байрладаг. Энэхүү ай савд гол мөрний сүлжээ маш бага бөгөөд нэгж талбайд ноогдох голын нийлбэр урт нь 0.01 км/км. кв-аас доош байдаг. Даланжаргалан сумын нутаг нь “Умард Говийн Гүвээт-Халхын Дундад Тал” усны сав газарт хамаарах бөгөөд гадаргын ус бараг байхгүй ба унд ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээнд газрын доорх усыг ашигладаг. Сансрын болон геологи-техтоникийн зураг, усны эрэл хайгуулын судалгааны дүнгээс харахад тектоникийн хагаралын бүсэд оршдог. Нүүрсний үе, давхраасууд нь синклиналь тогтоцтой, харьцангуй бага гүнд байрлах ба 5-10 градусын уналтай ба геологи, тектоникийн тогтоц нь энгийн бүтцийг үүсгэнэ. Усжилт бүхий тектоникийн хагарал, ан цав багатай, тохрол, өргөгдөл, суултанд олон удаа орсон блок байхгүй байна. Ул суурийн хурдас нь уст үе, давхарга багатай шаварлаг хурдас тухайлбал хар, хар саарал өнгийн аргиллит, алевролит, алевро-элсэнчулуу, шаварлаг чулуулгаас тогтох ба усжилт бага байдаг онцлогтой. Ордын гидрогеологийн нөхцлийн хувьд дээрх хүчин зүйлүүд **энгийн** нөхцөлтэй ангилалд оруулах боломжийг бүрдүүлж байна.

Амьтны аймаг: “Билэгт Баялаг” ХХК-ийн Зүүндалан, Далангийн төслийн ойр орчим говь, цөлийн амьтад голчлон тархсан ба ихэнх нь “Монгол орны 2 нутагтан, мөлхөгчдийн улаан данс-2006 он”, “Монгол орны шувууны улаан данс-2011 он “Бүс нутгийн болон олон улсын үнэлгээний анхааралд өртхөөргүй /LC/ буюу өргөн тархац нутагтай элбэг гэсэн зүйл ангилалд орсон байна. Алагтолгой орчмын нүүрсний орд нь олон жилийн турш уул уурхайн хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөний улмаас амьтны аймгийн төрөл зүйлээр ядмаг юм.

Түүх соёлын дурсгалт газрууд: Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд 2018 онд ШУА-ийн Палеонтологийн төвийн доктор Н.Ичинноровоор ахлуулсан баг судалгааны ажлыг хийсэн ба талбайд археологийн болон соёлын үнэт зүйл бүхий зүйлс илрээгүй байна.

Үржил шимт хөрсний овоолго: Шимт хөрсний хуулалтын ажил нь уурхай, овоолго, барилга байгууламж, зам талбай гэсэн үндсэн хэсгүүдээс хуулагдах бөгөөд нөхөн сэргээлтэнд ашиглагдах тул ойролцоох газарт байршуулна. Ашиглалтын жилүүдэд нийт 57.47 га талбайд шимт хөрс хуулалтын ажил гүйцэтгэх бөгөөд энэ нь 209.63 мян.м3 үржил шимт хөрс хуулж “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт хадгалалт MNS5916:2008” стандартыг баримтлан 5 метрээс илүүгүй өндөртэйгээр шимт хөрсний овоолго-1, шимт хөрсний овоолго-2-т хураан овоолно. Ил уурхайгаас хуулсан шимт хөрсийг одоогийн шимт хөрсний овоолго-1 буюу уурхайн зүүн урд буланд үргэлжлүүлэн байршуулна.

Гадаад овоолгын тэлэлтэд өртөх талбайн шимт хөрсийг овоолгын одоогийн шимт хөрсний талбай буюу хөрсний овоолгын баруун хойд талд, кемпийн урд талд нэмж байгуулна. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалтыг хуулах хөрсний үржил шимт үеийн агрохимийн шинж чанарын үзүүлэлтээс нь хамааруулан ялзмагийн агууламж 1% уусмалын орчинг тохируулан овоолгыг хийнэ. Шимт хөрсний овоолгыг хадгалах явцад салхинд хийсэх, усанд автах, хужиртах, хатуу биет, чулуу, барилгын болон бусад хаягдалд дарагдаж бохирдохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж хэлбэршүүлэн

ургамалжуулж хадгална.

Дэд бүтэц: Даланжаргалан сумын төвийг Улаанбаатар Сайншандын төмөр зам болон асфальтан хучилттай автозам дайран өнгөрдөг. Сумын төв нь Говь-Сүмбэр аймгийн төв Чойр хотоос 75 км-т байрладаг ба эргэн тойрныхоо сумдын төвтэй шороон замаар холбогддог. Өндөр хүчдэлийн шугамд холбогдсон, үүрэн телефоны бүх сүлжээ орсон. Уурхай орчимд хүн ам сийрэг суурьшдаг ба иргэд нь мал аж ахуй эрхлэн амьдардаг. Уурхайн хэмжээнд төв суурин газаргүй, харин уурхайгаас зүүн урагш 22 км-т Даланжаргалан сумын төв байрлана. Энд орон нутгийн засаг захиргааны нэгжүүдээс гадна сургууль, эмнэлэг, холбоо харилцаа, банкны салбарууд, шатахуун түгээх станц, сүм хийдтэй. Мөн олон тооны хувийн жижиг дэлгүүрүүд ажилладаг. Аймаг, сум, багийн төвүүд хоорондоо шороон замаар холбогдоно.

Физик-газар зүй: Уурхайн талбай нь намхан толгод зонхилсон тал хээрийн бүсэд багтах бөгөөд хамгийн өндөр цэг нь уурхайн талбайгаас зүүн хойш 3.7 км-т байрлах

1352.2 тоот өндөрлөг бол нам доор цэг нь уурхайн талбайгаас баруун тийш 7 км-т байрлах Бэхтийн-Улаан нуур /1179.6 м/ юм. Харьцангуй өндөржилт нь 50 м-с хэтрэхгүй.

Ус зүй: Тус бүс нутаг нь Төв Азийн гадагш урсгалгүй ай савын бүсэд хамаарах ба байгалийн ил задгай ус ховортой, жижиг булаг шанд цөөн тохиолдоно. Тухайн жилийн цаг уур, хур тунадасны хэмжээнээс хамаарч усны горим ихээхэн хувьсамтгай байдаг. Ахуйн хэрэглээнд худгийн ус хэрэглэх ба худгуудыг хуурай сайр, нуур тойрмуудыг бараадуулан гаргасан байдаг. Уурхайд хамгийн ойр байрлах бөгөөд харьцангуй ундарга сайтай худаг нь Өлзийт болон нэргүй худаг юм. Нэргүй худаг нь 190 л/цаг ундаргатай ба уурхайгаас зүүн тийш 6 км-т байрлана.

Хайгуулын ажил явуулсан талбай нь Алаг толгойн грабен синклиналь хотсын баруун жигүүрээр Баруун Далангийн ухаагийн зүүн энгэрийг даган байрлах ба геологийн тогтоц нь дээд юрагийн конгломератын давхраас, доод цэрдийн нүүрс агуулсан эх газрын бялхмал- тунамал хурдас ба дөрөвдөгчийн эх газрын тунамал хурдсаас бүрдэнэ.

Ногоон саарал, саарал өнгөтэй дунд том хайргатай конгломератын үе давхаргууд 78.55-207.99 м хүртэл үргэлжилнэ. Конгломератад агуулагдах хайрганы хэмжээ 1-4 см, том нь 6-8 см хүртэл байх ба мөлгөржилт нэлээн сайн. Конгломератыг бүрдүүлэгч гол чулуулаг нь риолит, риолит порфирит, риолит-дацат тэдгээрийн туфүүдээс бүрэлдэх бөгөөд

148.5-207.99 м-т ихэвчлэн тохиолдоно. Харин 78.55-148.5 м-ийн хооронд үелэг тогтоцтой, нарийн ширхэгтэй алевролит, янз бүрийн ширхэгтэй элсэн чулууны нимгэн үеүд бий. Нийтдээ 125.4 м зузаантай.

Ногоон саарал өнгийн нарийн ширхэгтэй цахиурлаг элсэн чулууны үе 66.4-78.55 м- т байна. Доод, дунд талдаа ойролцоогоор 1.0-5.0 мм-ийн мөхлөг бүтэцтэй гравелит, конгломератын үенд пиритийн талст агуулагдана.

Хар өнгөтэй, бүдэг, хагас бүдэг гялгатай нүүрсний давхраас 50.9-66.38 м-ийн хооронд янз бүрийн зузаантай 9 үеэс тогтжээ. Харин тэдгээрийн хооронд хар, хар саарал өнгийн нүүрслэг аргиллит, алевролит, элсэн чулууны үеүд байрлана. Нүүрсний үенд пирит заримдаа агуулагдана. Нүүрсний зузааныг каротажаар 5.17м гэж тогтоосон. Энэ давхраас нь МЗ юм.

Ногоон саарал, саарал өнгийн алевролит, янз бүрийн ширхэгтэй элсэн чулууны үеүд 17.1-50.9 м-ийн хооронд ээлжлэн тогтоно. Зарим хэсэгтээ том ширхэгтэй элсэн чулуу гравелитын үетэй. Нийтдээ 33.8 м зузаантай.

Хамгийн дээд талдаа орчин үеийн дөрөвдөгчийн 2-3 м-ийн зузаантай делюви, пролювийн гаралтай сэвсгэр хурдсаар хучигдсан янз бүрийн өнгөтэй, элсэн чулуу, алевролитоос голлоно. Зузааны хэмжээ 17.1 м орчим байдаг.

1.2. Зүүндалан, далангийн нүүрсний ордын нөөцийн тооцоо

Хүснэгт 2. Далан талбайд хамаарах нүүрсний нөөцийн нэгдсэн хүснэгт (Ордын нөөц 2020 оны 04-р сарын 01-ны байдлаар) /тусгай зөвшөөрлийн дугаар MV-021008/

№	Хэсэгшлийн дугаар, нөөцийн зэрэг	Хэсэгшлийн эзэлхүүн /м3/		Эзэлхүүн жин /т/м3/		Үлдэгдэл нөөц /тн/	
		цэвэр нүүрс	чулууны үетэй нүүрс	цэвэр нүүрс	чулууны үетэй нүүрс	цэвэр нүүрс	чулууны үетэй нүүрс
M1 давхарга							
1	1В-1	1,196,887.96	1,206,962.78	1.30	1.43	200,458.46	222,360.40
2	1С-2	123,296.27	125,136.51	1.30	1.43	76,293.38	85,175.29
3	1С-3	105,673.43	108,383.00	1.30	1.43	69,052.13	77,904.97
M1 давхарга нийт		1,425,857.66	1,440,482.29			345,803.97	385,440.67
Бодитой В нөөц		1,196,887.96	1,206,962.78			200,458.46	222,360.40
Боломжтой С нөөц		228,969.70	233,519.51			145,345.51	163,080.26
M2 давхарга							
4	2А-1	208,729.90	208,729.90	1.30	1.41	271,348.87	294,309.16
5	2А-2	223,349.00	223,349.00	1.30	1.41	290,353.70	314,922.09
6	2А-3	285,799.63	285,799.63	1.30	1.41	371,539.52	402,977.48
7	2А-4	192,560.78	192,560.78	1.30	1.41	250,329.01	271,510.70
8	2А-5	318,669.75	318,669.75	1.30	1.41	400,756.40	434,666.55
9	2С-6	24,479.59	24,479.59	1.30	1.41	28,487.94	30,898.46
10	3В-1	191,296.27	191,296.27	1.30	1.41	248,685.15	269,727.74
11	3В-2	159,925.00	159,925.00	1.30	1.41	207,902.50	225,494.25
12	3В-3	68,764.54	68,764.54	1.30	1.41	89,393.91	96,958.01

13	3B-4	170,228.88	170,228.88	1.30	1.41	221,297.55	240,022.72
14	4B-1	747,133.40	751,454.59	1.30	1.41	926,007.27	1,010,170.65
15	4C-2	34,274.23	34,274.23	1.30	1.41	14,026.77	15,213.65
16	4C-3	68,650.73	70,367.00	1.30	1.41	89,245.95	99,217.47
17	4C-4	141,843.90	145,390.00	1.30	1.41	184,364.10	204,963.24
18	5C-1	385,912.86	385,912.86	1.30	1.41	501,686.72	544,137.14
М2 давхарга нийт		3,221,618.47	3,231,202.03			4,095,425.35	4,455,189.30
А+В+С нөөц		3,221,618.47	3,231,202.03			4,095,425.35	4,455,189.30
Баттай А нөөц		1,229,109.06	1,229,109.06			1,584,327.50	1,718,385.98
Бодитой В нөөц		1,337,348.09	1,341,669.28			1,693,286.37	1,842,373.37
Боломжтой С нөөц		655,161.32	660,423.69			817,811.48	894,429.95
М3 давхарга							
19	7A-1	125,135.87	125,135.87	1.30	1.37	162,676.64	171,436.15
20	7A-2	139,805.82	139,805.82	1.30	1.37	181,747.57	191,533.97
21	7A-3	104,016.97	104,873.78	1.30	1.37	135,222.06	143,677.08
22	7A-4	99,121.36	99,121.36	1.30	1.37	128,857.77	135,796.26
23	7A-5	180,048.96	181,516.35	1.30	1.37	234,063.65	248,677.40
24	7C-6	15,535.64	15,535.64	1.30	1.37	20,196.34	21,283.83
25	8B-1	101,071.18	101,071.18	1.30	1.37	131,392.53	138,467.51
26	8B-2	113,437.39	113,437.39	1.30	1.37	147,468.60	155,409.22
27	8B-3	41,195.64	41,195.64	1.30	1.37	53,554.33	56,438.03
28	8B-4	96,850.91	97,614.72	1.30	1.37	125,906.18	133,732.17
29	8C-5	234,049.22	234,049.22	1.30	1.37	304,263.99	320,647.43
30	9B-1	525,840.88	525,840.88	1.30	1.37	683,593.14	720,402.00
31	9C-2	34,147.18	34,147.18	1.30	1.37	44,391.34	46,781.64
32	9C-3	30,897.00	30,897.00	1.30	1.37	40,166.10	42,328.89
33	9C-4	65,447.00	65,447.00	1.30	1.37	85,081.10	89,662.39
34	10C-1	66,427.00	66,427.00	1.30	1.37	86,355.10	91,004.99
35	11P1-1	297,017.41	297,017.41	1.30	1.37	386,122.64	406,913.86
36	12P1-1	1,764,722.86	1,764,722.86	1.30	1.37	2,294,139.72	2,417,670.32
М3 давхарга нийт		4,034,768.30	4,037,856.31			5,245,198.79	5,531,863.15
А+В+С нөөц		1,973,028.03	1,976,116.04			2,564,936.44	2,707,278.98
Баттай А нөөц		648,128.99	650,453.19			842,567.68	891,120.87
Бодитой В нөөц		878,395.99	879,159.80			1,141,914.79	1,204,448.93
Боломжтой С нөөц		446,503.05	446,503.05			580,453.96	611,709.18
Илрүүлсэн баялаг P1		2,061,740.27	2,061,740.27			2,680,262.35	2,824,584.17
Нийт нөөц А+В+С		6,620,504.17	6,647,800.36			7,006,165.76	7,547,908.94
Нийт баттай А нөөц		1,877,238.05	1,879,562.25			2,426,895.18	2,609,506.85
Нийт бодитой В нөөц		3,412,632.05	3,427,791.86			3,035,659.63	3,269,182.70
Нийт боломжтой С нөөц		1,330,634.07	1,340,446.25			1,543,610.95	1,669,219.40
Илрүүлсэн баялаг P1		2,061,740.27	2,061,740.27			2,680,262.35	2,824,584.17

1.3. Уурхайн ажиллах горим

Уурхай нь жилд баяр ёслолын, амралтын өдрөөс бусад бүх өдөр ажиллана. Жилд ажиллах хоног, ээлжийн үргэлжлэх хугацааг компанийн баталсан “Зүүндалан, Далангийн нүүрсний ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах техникийн нөхцөл”-ийн дагуу болон цар тахлын үеийн нөхцөл байдал, уурхайн өнөөгийн уулын ажлыг горимыг үндэслэн дор дурдсан горимоор ажиллахаар төсөлд тусгасан.

Хүснэгт 3. Ил уурхайн уулын ажлын горим

№	Үзүүлэлт	Хэмжих	Хэмжээ	
		нэгж	Хөрс	Нүүрс
1	Хуанлийн хоног	хоног	365	365
2	Баяр ёслолын хоног	хоног	15	15
3	Засвар үйлчилгээ	хоног	25	25
4	Бэлтгэл ажлын хоног	хоног	10	10
5	Төлөвлөгөөт бус сул зогсолт	хоног	30	30
6	Цаг агаарын саатал	хоног	15	15
7	Уурхайн жилд цэвэр ажиллах хоног	хоног	270	270
8	Хоногт ажиллах ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12	12
9	Ээлжийн тоо	ш	2	2
11	Ээлжин дэх сул зогсолт (үдийн цай, тос түлш нэмэх)	цаг	1	1
12	Ээлжийн бэлтгэл, төгсгөл	цаг	1	1
13	Өдрийн сул зогсолт	цаг	0	0
14	Бүтээлтэй ажиллах цаг	цаг	10	10
15	Цаг ашиглалт		0.83	0.83

Уурхай хоногт 2 ээлж, 12 цагаар ажиллана. Ээлжийн ажилчдыг уурхайн даргын баталсан тусгай хуваарийн дагуу амрааж үйлдвэр зогсолтгүй ажиллах байдлаар зохицуулна.

1.4. Үйлдвэрлэлийн нөөц

Уурхайн 2026 онд балансын нөөцөөс 95.0 мян.тн нүүрс олборлон борлуулсан байна. Нийт нүүрсний хаягдал 1.0 мян.тн байна. Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог дараах хүснэгтэд үзүүллээ.

Хүснэгт 4. Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо

№	Нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт
1	Уулын цул	мян.м ³	2073.2
2	Нүүрсний хэмжээ	мян.тн	550.468
3		мян.м ³	390.372
4	Хөрсний хэмжээ	мян.м ³	1682.98
5	Хөрс хуулалтын пלטгэлцүүр	м ³ /тн	3.05
6		м ³ /м ³	4.31

Хүснэгт 5. “Зүүндалан, далан” уурхайн нүүрсний 2026 оны төлөвлөгөө

Үзүүлэлт	Хэмжээний нэгж	Жилийн төлөвлөгөө	1-р улирал				2-р улирал				3-р улирал				4-р улирал			
			1	2	3	Дүн	4	5	6	Дүн	7	8	9	Дүн	10	11	12	Дүн
Хөрс хуулалт	мян. м ³	1856,05	140.24	140.24	140.24	420,74	140.24	140.24	140.24	420,74	140.24	140.24	140.24	420,74	140.24	140.24	140.24	420,74
Нүүрс олборлолт	мян. тн	550.468	45.87	45.87	45.87	137.61	45.87	45.87	45.87	137.61	45.87	45.87	45.87	137.61	45.87	45.87	45.87	137.89
Нүүрс борлуулалт	мян. м ³	390.372	32.53	32.53	32.53	97,593	32.53	32.53	32.53	97,593	32.53	32.53	32.53	97,593	32.53	32.53	32.53	97,593
Нүүрс борлуулалт	мян. тн	550.468	45.87	45.87	45.87	137.61	45.87	45.87	45.87	137.61	45.87	45.87	45.87	137.61	45.87	45.87	45.87	137.61
Уулын ажлыг			Нэгж		1-р улирал		2-р улирал		3-р улирал		4-р улирал		Нийт					
Уулын цул			мян.м ³		518.33		518.33		518.33		518.33		2073.2					
Нүүрс олборлолт			мян.тн		137.10		137.10		137.10		137.10		550.468					
Нүүрс олборлолт			мян.м ³		97,593		97,593		97,593		97,593		390.372					
Нийт			м ³ /тн		1.41		1.41		1.41		1.41		1.41					
Хөрс хуулалт			мян.м ³		499.19		499.19		499.19		499.19		1996.76					
Хөрс хуулалтын коэффициент			м ³ /тн		3.38		3.38		3.38		3.38		3.38					
Шимт хөрс хуулалт			мян.м ³		10.31		10.31		10.31		10.31		41.27					
Талбай шимт хөрс			Га		3.43		3.43		3.43		3.43		13.74					
Талбай шимт хөрс			мян.м ²		34.36		34.36		34.36		34.36		137.46					
Хуулах хөрсний зузаан			м		0.3		0.3		0.3		0.3		0.3					
Уурхай			мян.м ³		5.21		10.31		10.31		10.31		36.17					
Уурхайн талбай			Га		1.73		3.43		3.43		3.43		12.04					
Уурхайн талбай			мян.м ²		17.3		34.36		34.36		34.36		120.46					
Хуулах хөрсний зузаан			м		0.3		0.3		0.3		0.3		0.3					
Овоолго			мян.м ³		5.1		0		0.0		0.0		5.1					
Овоолгын нийт талбай			Га		1.7		0		0.0		0.0		1.7					
Овоолгын нийт талбай			мян.м ²		17		0		0.0		0.0		17					
Хуулах хөрсний зузаан			м		0.3		0.3		0.3		0.3		0.3					

Хүснэгт 6. Уулын ажлын механикжуулалтын бүтэц

Ажил	Процессууд (тоног төхөөрөмж)	
Шимт хөрс хуулалт	Ухаж түрэх	Овоолох
	Бульдозер	Бульдозер
Хөрс хуулалт	Ухаж ачих	Овоолго
	Экскаватор	Бульдозер
Нүүрс олборлолт	Экскаваци	Гадаад тээвэр
	Экскаватор	Автосамосвал

1.5. Үйлдвэрлэлийн процессууд

Хөрс хуулалтанд туслан гүйцэтгэгчийн HYUNDAI-R520LC маркийн 5 ширхэг, DOOSAN-DX700LC маркийн 1 ширхэг экскаватор, HOWO, NORTHBENZ маркийн 25 тн- ийн даацтай 12 автосамосвал, HOWO-371 маркийн 60 тн даац бүхий 4 ширхэг автосамосвалтай хослон ажиллана.

Уурхайн хүчин чадал, техникийн бүтээл, бэлэн байдлын коэффициент зэргийг тооцож үзэхэд хөрс хуулалтанд 4 экскаватор, 16 автосамосвал ажиллахаар тооцсон.

Хүснэгт 7. Хөрс хуулалтын хэмжээ

№	Ашиглалтын жил	Хөрс хуулалтын хэмжээ мян.м ³
1	2025 он	1682.98

Хүснэгт 8. Хөрсний экскаваторын бүтээл

№	DOOSAN-DX700LC экскаваторын бүтээл	Хэмжээ	№	HYUNDAI-R520LC экскаваторын бүтээл	Хэмжээ
1	Цагийн бүтээл, м ³ /цаг	350	1	Цагийн бүтээл, м ³ /цаг	190
2	Ээлжийн бүтээл м ³ /ээлж	2,650	2	Ээлжийн бүтээл м ³ /ээлж	1,450
3	Хоногийн бүтээл, м ³ /хон	5,300	4	Жилийн бүтээл м ³ /жил (1 ээлжээр)	350,000
4	Жилийн бүтээл мян.м ³ /жил	1,180			

Хүснэгт 9. Хөрсний экскаваторын шаардлагатай тоо

№	Ашиглалтын жил	Хөрс хуулалтын хэмжээ м ³	Экскаваторын жилийн бүтээл м3	Тоо
1	2025	1682.98	1,302,000	1
			380,000	5

1.6. Хөрс тээвэрлэх процесс

№	Howo-25 автосамосвалын бүтээл	Хэмжээ
1	Цагийн бүтээл м ³ /цаг	31.2
2	Ээлжийн бүтээл м ³ /ээлж	312
3	Хоногийн бүтээл м ³ /хон	624
4	Жилийн бүтээл м ³ /жил	140000



1.7. Нүүрс олборлолтын процесс

Нүүрс олборлолтын ажил зөвхөн өдрийн ээлжээр явагдана. Нүүрсийг мөргөцгөөс 3.2 м3 утгуурын багтаамжтай Hyundai 500LC маркийн экскаватораар northbenz маркийн 25 тонн даацтай автосамосвалд ачина.

Нүүрсний үеийн зузаан, мөргөцгийн нөхцөл, операторын ур чадвараас хамаараад экскаваторын утгуур дүүргэлт 70~80%, автосамосвалд хийх ачилтын тоо 8-12 байна. Нүүрс олборлолтын ажилд 4 ширхэг Hyundai 500LC, northbenz маркын 16 ш автосамосвал ажиллана.

Хүснэгт 10. Нүүрс олборлолтын хэмжээ

№	Ашиглалтын жил	Нүүрс олборлолт тн	Нүүрс олборлолт м ³
1	2025	550468	390372

Хүснэгт 11. Нүүрсний экскаваторын бүтээл

№	Hyundai 500LC экскаваторын бүтээл	Хэмжээ
1	Цагийн бүтээл, м³/цаг	92
2	Ээлжийн бүтээл м³/ээлж	700
3	Жилийн бүтээл м³/жил	170,000



№	Ашиглалтын жил	Нүүрс олборлолт м³	Экскаваторын жилийн бүтээл м³	Тоо
1	2025	392,150	170,000	3

Нүүрсийг 3.2 м³ утгуурын багтаамжтай SEM-652B утгуурт ачигчаар 70 тонн даацтай автосамосвалд ачина. 2 ш утгуурт ачигч ажиллана.

SEM-652B утгуурт ачигчын бүтээл	Хэмжээ
Цагийн бүтээл, м³/цаг	102
Ээлжийн бүтээл, м³/ээлж	1,020
Хоногийн бүтээл, м³/хоног	2,040
Жилийн бүтээл, м³/жил	510,000



Үзүүлэлт	Doosan-DX700
Утгуурын багтаамж, м³	4.5
Хөдөлгүүрийн чадал, кВт	345
Нийт жин, кг	70000
Гарны урт, м	8.4
Мах хурд км/цаг	5.2
Жилийн бүтээл, м³	1180000



Үзүүлэлт	CAT-325DL
Утгуурын багтаамж, м³	1.6
Хөдөлгүүрийн чадал, кВт	103
Нийт жин, кг	35100
Гарны урт, м	3.2
Мах хурд км/цаг	5.5
Жилийн бүтээл, м³	275000



Үзүүлэлт	Shacman
Даац, тн	70
Хөдөлгүүрийн чадал	426 м.х
Нийт жин, тн	25
Тэвшний багтаамж, м³	65
Хурд км/цаг	75
Жилийн бүтээл, м³	95660



Үзүүлэлт	Howo-371
Даац, тн	70
Хөдөлгүүрийн чадал	371 hp
Мах хурд км/цаг	70
Жилийн бүтээл, м³	400000



Үзүүлэлт	Nordbenz
Даац, тн	25
Хөдөлгүүрийн чадал	371 м.х
Нийт жин, тн	13.7
Тэвшний багтаамж, м³	18.2
Хурд, км/цаг	70
Жилийн бүтээл, м³	160000



Үзүүлэлт	Sunward SWDE120
Өрмийн машины тэнхлэгийн даралт	140
Хөдөлгүүрийн чадал	254 кв
Түлш зарцуулалт	40 л/цаг
Өрмийн хошууны диаметр	0.12 м
Өрөмдөх гүн	24 м
Өрмийн хошууны эргэлтийн давтамж	2.86 эрг/сек
Штангны урт	4 м
Жилийн бүтээл	152796.65



Үзүүлэлт	SEM-822
Хутганы багтаамж	6.4 м³
Хутганы урт	4617 мм
Хутганы өндөр	1511 мм
Явах ангийн өргөн	2620 мм
Хамгийн их хутганы зоогдох гүн	540 мм
Сийрүүлэгчийн хамгийн их зоогдох гүн	655 мм
Ажлын жин	24600 кг
Хөдөлгүүрийн хүчин чадал	162 кВт



Үзүүлэлт	SDLG G9190
Хөдөлгүүрийн чадал	146 кВт
Хөдөлгөөний давших дээд хурд	5.4-38 км/цаг
Хөдөлгөөний үхрэх дээд хурд	5.4-24
Эргэлтийн радиус	7.8 м
Ухах хамгийн их гүн	500 мм
Хусуурын хамгийн их эргэлтийн өнцөг	20 градус
Хусуурын өргөн	3.96 м
Жин	15.8 тн



Замын тоос дарах ажиллагаа: Орон нутгийн уур амьсгал, замын хөдөлгөөний эрчим, тухайн замын тоосжилтын байдлаас хамааран замын тоос дарах ажлыг 4-10 сар буюу дулааны улиралд ээлжинд 4 удаа явуулна. 11-3-р сард буюу өвлийн улирал замыг грейдерээр хусаж цэвэрлэнэ. Усны машин нь тодорхой чиглэлийн дагуу явж замын тоос дарж ус шүршинэ. Шаардлагатай тохиолдолд замыг хэсэгчлэн тоос дарах ажиллагааг хэрэгжүүлнэ. Замын тоос дарах ажиллагаанд 25 тн багтаамжтай БНХАУ-д үйлдвэрлэсэн усны машин ашиглана.


Нүүрс бутлах үйл ажиллагаа: Далангийн нүүрсний уурхайн ТЭЗҮ-д тусгагдсанаар жилийн 600 мян.тн нүүрс олборлох ба үүний 75% орчмыг бутлах шаардлагатай буюу сард бутлах шаардлагатай нүүрсний хэмжээ 47 мян.тн, хоногт бутлах шаардлагатай нүүрсний хамгийн хэмжээ 1400 тн байна. Ачаалал ихтэй үе гарч болзошгүй учраас 2 бутлуур сонгож нүүрс олборлолтын ажил багатай өдөр нэг бутлуурыг зогсоож нөөцөд байлгана. Хэрэв аль нэг бутлуурт эвдрэл гэмтэл гарч, засвар үйлчилгээний ажил хийж зогсвол нөгөө бутлуур нь дангаараа нүүрс бутлах ажлыг зогсоохгүй ажиллах чадалтай байна.

“Билэгт Баялаг” ХХК-ийн одоо ашиглаж байгаа нүүрсний талбай байрлах зөөврийн дизель, цахилгаан хосолсон НК6126 бутлуур нь цагт 170 тн/цаг хүчин чадалтай бөгөөд хоногт 1 ээлжээр 11 цаг ажиллахад 1870 тн нүүрс буталж хүчин чадалтай учраас дээрх бутлуурыг ашиглалтын хугацаанд нөөцөд 1ш нэмж авахаар тооцсон байна.



Уурхайн барилга байгууламж: Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайн удирдлага, инженерийн баг, нүүрсний борлуулалт, гадаад тээвэрлэлтийн ажлыг хариуцаж ажиллана. Уулын бүхий л ажлыг гэрээт туслан гүйцэтгэгчдээр хийгддэг. Уурхайн үндсэн болон туслан гүйцэтгэгчийн кемпүүд нь биеэ даасан цогцолбор байдлаар байгуулагдсан. Одоогийн уурхайн хэрэгцээнд ашиглагдаж буй захиргаа, засвар үйлчилгээ болон бусад туслах барилга байгууламжуудтай бөгөөд шаардлагатай хэрэгцээг хангахуйцаар уурхайн талбайн цогцолбор барьж байгуулагдсан гэж ойлгож болно. Туслан гүйцэтгэгчийн кемп-д уурхайн өдөр тутмын ажлын наряд-аюулгүй ажиллагаа зааварчилгааны хэсэг, захиргаа гэх мэт бүх хэлтсийн ажлын байрыг тус бүрт нь байгуулан ажиллаж байна. Төсөл хэрэгжүүлэгч нь өөрийн хөрөнгөөр 80 хүн амьдарч ажиллах бүхий кемпийг тусгай зөвшөөрлийн талбайн баруун талд барьж байгуулсан. Туслан гүйцэтгэгчид нь үндсэн кемпд хамт байрлах бөгөөд удирдлага, уурхайн ИТА нар нь тусдаа 4 ш тусгайлан тохижуулсан контейнерт кемпийн хойд хэсэгт байрлах бөгөөд үүнд 16 хүний багтаамжтай.

Зураг 2. Уурхайн барилга байгууламж



Засвар үйлчилгээний төв: 2023 онд шинээр засвар үйлчилгээний төв барьж ашиглалтанд оруулсан. Уг засварын байр нь автосамосвалууд болон хүнд даацын машин механизмын засвар үйлчилгээг хийх, тос тосолгооны материал хадгалахаар зориулагдсан.

Зураг 3. Засварын байр



Шатах тослох материалын агуулах: ШТС-ын түр агуулах нь уурхайн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөхгүй газарт байрласан байх шаардлагатай ба одоогийн нөхцөлд засварын төв талбайн зүүн талд тугайлан зориулж тоногдсон 20 тн багтаамж бүхий 1ш юмкост, 2 түгээгүүр ашиглаж байна. Төслийн хугацаанд энэ байрлалд нь ашиглахаар төлөвлөсөн бөгөөд жил тутам баталгаажуулж, аюулгүй байх, байгаль орчинд хор хөнөөлгүй байх тал дээр тусгайлан анхаарч ажиллахаар төлөвлөсөн.

Зураг 4. ШТС



1.8. Уурхайн ажиллах хүчин чадал, хүний нөөц

Ил уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэснээр шууд ажлын байраар нийт 179 хүнийг хангана. Захиргааны хэсэгт нийт 30, ил уурхайн болон бутлах хэсэгт 98, бусад хэсэгт 52 тус тус ажиллаж байна. Нийт ажилчдын 23 ажилтан нь төсөл хэрэгжүүлэгч компаний ажилтнууд байх ба бусад ажилчид нь туслан гүйцэтгэх компанийн ажилчид байна.

Зүүндалан, Далангийн нүүрсний уурхайн тэсэлгээний ажлыг гэрээт компаниар гүйцэтгүүлнэ. Ил уурхайн тэсэлгээний ажлыг 15 хоногт нэг удаа хийх ба жилд 19-20 удаа тэсэлгээний ажлыг явуулна. Ил уурхайн уулын цулыг энгийн тэсрэх бодис ANFO-оор тэслэх ба устай цооногт эмульсний тэсрэх бодис хэрэглэнэ.

3-р давхаргын хөрс хуулалтын үед устай нөхцөлд тэсэлгээ хийгдэх төлөвтэй байна.

Хөрсний мөргөцөгт цооногийн торны хэмжээ 4.5x3.6, тэсрэх бодисын хувийн зарцуулалт 0.458 кг/м3

Хүснэгт 12. Хөрсний мөргөцгийн тэсэлгээний параметр /2018 онд батлагдсан ТЭЗҮ- ийн дагуу үндсэн үзүүлэлтүүдийг авав. Цооногийн диаметрийг зэргэлдээх уурхайн үзүүлэлтээр сонгов./

№	Тэмдэглэгээ	Үзүүлэлт	Нэгж	Хөрс
1	Gш	Чулуулгийн шахалтын бат бөхийн хязгаар	мПа	45.20
2	Gс	Чулуулгийн суналтын бат бөхийн хязгаар	мПа	17.82
3	Gши	Чулуулгийн шилжрэлтийн бат бөхийн хязгаар	мПа	28.10
4	βч	Чулуулгийн нягт	т/м3	1.80
5	qж	Тэсрэх бодисын жишиг хувийн зарцуулалт	гр/м3	43.65
6	Kтб	Тэсрэх бодисыг жиших илтгэлцүүр	-	1.10
7	Kцб	Цэнэгийн бөөгнөрлийг тооцох илтгэлцүүр	-	0.95
8	Kца	Чул-н цавшлын зэргийг тооцох илтгэлцүүр	-	1.27
9	Kдб	Чул-н дундаж бутлагдлыг тооцох илтгэлцүүр	-	1.57
10	Kиг	Ил гадаргыг тооцох илтгэлцүүр	-	3.5
11	Kэз	Цооногийн цэнэгт хамаарах эзлэхүүнийг тооцох илтгэлцүүр	-	1.44
12	qt	Тэсрэх бодисын тооцооны хувийн зарцуулалт	гр/м3	458
13	dцo	Цооногийн оновчтой диаметр	м	0.12
14	Нд	Доголын өндөр /3-р давхаргын хучаас хөрсний	м	7.00

Хүснэгт 13. Хөрсний мөргөцгийн тэсэлгээний ажлын тооцооны нэгдсэн үзүүлэлт

№	Тэмдэглэгээ	Үзүүлэлт	нэгж	Хөрс
1	f	Чулуулгийн бат бэх (f)		5.80
2	dцo	Цооногийн диаметр /сонгож авсан/	м	0.12
3	N	Ил гадаргын тоо (N)	ш	3
4	Нд	Доголын өндөр	м	7
5	α	Доголын хажуугийн өнцөг	градус	65
6	C	Өрөмдлөг аюулгүй явагдах зай (C зай)	м	1
7	We	Улны эсэргүүцлийн шугам (өрөмдөгдөх нөхцөлөөр)	м	4.26
8	W	Улны эсэргүүцлийн шугам (тэсэлгээний нөхцөлөөр)	м	4.28
	W>We нөхцөл	ҮНЭН		
9	W	Сонгосон улны эсэргүүцлийн шугам	м	4.3
10	m	Цооног ойртолтын илтгэлцүүр		0.8
11	a	Цооног хоорондын зай	м	3.4
12	b	Эгнээ хоорондын зай	м	4.1
13	пэг	Эгнээний тоо	ш	20
14	lнө	Илүү өрөмдлөгийн гүн	м	0
15	Lцo	Цооногийн гүн	м	7.0
16	Lт	Түгжээсний урт	м	1.80
17	Lцэ	Цэнэгийн урт	м	5.20
18	qж	Тэсрэх бодисын тооцооны хувийн зарцуулалт	кг/м3	0.458
19	Δ	Цэнэглэлтийн нягт	кг/дм3	0.8
20	Pцo	1 м цооногт орох тэсрэх бодисын хэмжээ	кг/м	9.04
21	Qцo	1 цооногт орох тэсрэх бодисын хэмжээ	кг/цооног	47.02
22	g	1 м цооногоос гарах уулын цулын хэмжээ	м3/м	14.11
23		Жилд тэслэх уулын цулын хэмжээ	мян.м3	1996.76
24		Жилд тэслэгдэх цооногийн тоо	ш	20367
25		Жилд хэрэглэгдэх тэсрэх бодисын хэмжээ	тонн	914.516
26		Жилийн өрөмдлөгийн хэмжээ	м	142569
27	Наг	Жилд хийх тэсэлгээний тоо	удаа	31
28		Тэсэлгээний мөчлөг	хоног	9
29		Нэг тэсэлгээний блокийн хэмжээ	м3	64,879.2
30		Нэг удаагийн тэсэлгээний блокт хамаарах цооногийн тоо	ш	657
31		Блок дахь дундаж эгнээний тоо	ш	20
32		Нэг удаагийн тэсэлгээнд орох тэсрэх бодис	тонн	29.74

Тэсрэх бодис болон тэсэлгээний материалын зарцуулалт: Чулуулгийн тэслэгдэх үзүүлэлт, тэсрэх бодисын зарцуулалтыг ТЭЗҮ-ийн дагуу тооцоонд орууллаа. Мөн тэсрэх бодисын зарцуулалтыг ТЭЗҮ- д дурдсан нүүрсний зарцуулалтаар буюу 0.38 кг/м³ гэж алдаатай мэдээлэл оруулсан байсныг энд засварлаж хөрсний зарцуулалт буюу 0.458 кг/м³- ээр орууллаа.

Цооногийн диаметрийг 120 мм байхаар шинэчлэн тооцоолсон тул өмнөх тооцооноос цооногийн тоо нэмэгдсэнийг энд дурдах нь зүйтэй.

2026 онд тэсэлгээний ажлаар буталж сийрэгжүүлэх 988.68 мян.м³ хөрс хуулалтын ажилд зарцуулагдах тэсрэх бодис болон тэсэлгээний ажлын зарцуулалтын тооцоог доор үзүүллээ.

Тэсрэх бодис: Уурхай 2-р давхаргын олборлолтыг хийж эхэлсэн. Усны түвшин уурхайн зүүн урд хэсэгт 2-р давхаргын таазаар, хойд хэсэгтээ 2-р давхаргын уланд байна. Эхний ээлжид 2-р давхаргын хучаас хөрсийг тэслэхэд усгүй нөхцөлд ANFO тэсрэх бодисыг ашиглана. Харин 3-р давхаргын хөрс хуулалтыг 100% устай нөхцөлд хийх урьдчилсан төлөвлөгөө гарсан. Нийт тэслэгдэх 1996.76 мян.м³ хөрсний:

2-р давхаргын хучаас хөрс нь: 894.54 мян.м³ буюу 44.8% - ANFO

3-р давхаргын хучаас хөрс нь: 1,102.21 мян.м³ буюу 55.2% - Эмульс

1 м³ хөрсний цулын тэсрэх бодисын зарцуулалт 0.458 кг/м³ болох тул нийт 1996.76 мян.м³ хөрсийг тэслэхэд $0.458 \text{ кг/м}^3 * 1996.76 \text{ мян.м}^3 = 914.516 \text{ тн}$ шаардлагатай. Усгүй болон усгүй нөхцөлийн хувиар тооцоолбол ANFO тэсрэх бодис 409.7 тн, Эмульсийн тэсрэх бодис 504.81 тн тус тус шаардагдахаар байна.

Бүүстер /өдөөгч/ зарцуулалт: 1 удаагийн тэсэлгээнд дунджаар 657 цооног өрөмдөнө. Тиймээс цооногийн үндсэн цэнэгийг өдөөх тэсрэх бодис /бүүстер/ 657 ш орно. Жилд 31 удаа тэсэлгээ хийгдэх тул $657 \text{ ш} * 31 \text{ удаа} = 20367 \text{ ш}$ зарцуулагдана.

Пахилгаан бус тэслүүр /нонель/: 1 удаагийн тэсэлгээнд дунджаар 657 цооног өрөмдөнө. Өдөөгч тэсрэх бодисыг тэслэх цооногийн нонель мөн адил тоогоор буюу 657 ш орно. Жилд 31 удаа тэсэлгээ хийгдэх тул $657 \text{ ш} * 31 \text{ удаа} = 20367 \text{ ш}$ зарцуулагдана.

Цочир дамжуулах шижим: 1 удаагийн тэсэлгээний блокийн урт дунджаар 112 м, цооногийн эгнээний тоо 20 байх тул гадаргуугийн холбогчийн /Цочир дамжуулах шижим/ урт нөөц тооцсон дүнгээр ойролцоогоор $112 \text{ м} * 20/2 \text{ эгнээ} + 10\% = 1232 \text{ м}$ болно.

Жилд 31 удаа тэсэлгээ хийгдэх тул $1232 \text{ м} * 31 \text{ удаа} = 38192 \text{ м}$ зарцуулагдана.

Гал дамжуулах шижим: 1 удаагийн тэсэлгээний ажилд дунджаар үндсэн тэсэлгээнд гал өгөхөд 2 м, бялт тэслүүрээр 3 удаа дохио өгөхөд $6 * 0.5 \text{ м} = 3.0 \text{ м}$, нийт 5 м орчим шаардагддаг. Жилд 31 удаа тэсэлгээ хийгдэх тул $5 \text{ м} * 31 \text{ удаа} = 155 \text{ м}$ зарцуулагдана.

Дуут дохио: Тэсэлгээний ажлыг тусгай дуут дохио ашиглан гүйцэтгэнэ. Эхний дохиог 1 удаа өгч аюултай бүсийг хамгаалалтад авах, 2 дахь дохиог 2 удаа өгч тэсэлгээний ажлыг явуулах, 3 дахь дохиогоор 3 удаа өгч тэсэлгээний ажил дууссаныг зарлана.

Хүснэгт 14. Тэсрэх бодис болон тэслэх хэрэгслийн зарцуулалт

№	Тэслэх хэрэгсэл, тэсрэх бодисын үндсэн түүхий эдийн төрөл	Тэслэх хэрэгсэл, тэсрэх бодисын үндсэн түүхий эдийн төрлийн хэлбэрүүд	Код	Нэгж	2025 оны төлөвлөгөө
Тэсрэх бодис					
1	Эмульсийн тэсрэх бодис	савлагаатай, тэслүүрт мэдрэмтгий	3602	кг	504,802
2	Анфо тэсрэх бодис	энгийн найрлагатай, савлагаатай 25 кг	3602	кг	409703
3	Бүүстер /өдөөгч/	цооног, шпурын	3603	ш	914516
Тэслэх хэрэгсэл					
4	Цахилгаан бус тэслүүр /нонель/	цооногийн болон гадаргуугийн холбогч блоктой хосолсон	3603	ш	20367
5	Цочир дамжуулах шижим	гадаргуугийн холболтын бага хүчин чадлын /савлагаа 50-100 м/	3603	м	38192
6	Гал дамжуулах шижим /ОШП/	-	3603	м	155

Хүснэгт 15. Жилийн нийт цахилгааны хэрэглээ

№	Цахилгаан хэрэглэгч	Нийт чадал кВт	Жилд ажиллах цаг Цаг/жил	Жилийн нийт хэрэглээ МВт/жил
1	Нүүрс бутлах хэсэг	61.05	6,000.0	366.3
2	Хотхон	56.54	7,884.0	445.7
3	Засварын цех	40.63	3,200.0	130.0
4	Ил уурхай	206.25	6,400.0	1,320.0
5	Гэрэлтүүлэг	0.3240	3,840.0	1.244
6	НИЙТ			2,263.24
7	Цахилгаан эрчим хүчний үнийн тариф	Төг кВт.цаг		155.9

1.9. Усан хангамж

Усны сав газар: Умарт говийн гүвээт-Халхын дундат талын сав газар Уурхайн хүн амын унд, ахуйн хэрэглээнд нийт 4000 тн ус хэрэглэнэ.

- 1 хүн өдөрт унд 10 литр ус хэрэглэнэ.
- 1 хүний өдөрт ахуйн хэрэглээнд 125 литр ус хэрэглэнэ.

Хүснэгт 16. 2026 оны усны хэрэглээ

Төрөл	1 хүн өдөрт	хоног	Хэрэглэгч	Тоон утга
Унд	10 литр	310	120	372 тн
Ахуйн хэрэглээ	125 литр	310	120	4,650 тн
Нийт хэрэглээ				5,600тн

1.10. Уурхайн ус таталт Нүүрст давхаргын шинж чанар

Уурхайд усны шүүрэл харьцангуй бага. Бага хэмжээгээр ус шүүрэх хэдий боловч уулын ажилд хүндрэл учруулахгүй. Хур борооны нөлөөгөөр ил уурхайн талбайн хэмжээгээр ус цугларна.

Уурхайн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй, найдвартай явуулахад ил уурхайд орж ирэх усыг зайлуулах, нүүрсний үе, давхраас, уурхайн мөргөцгийг хуурайшуулах, шүүрүүлэх ажлыг зайлшгүй гүйцэтгэнэ. Газар доорх усны түвшнийг эхний ээлжид 13-20 м-ээр, цаашид ашиглалтын үеийн гүний хэмжээнд 20-30 м бууруулах ажил хийгдэнэ. Хэдийгээр байнгын ус шавхалтын ажил хийгдэхгүй боловч бэлэн байдалд ус зайлуулах ажилд бэлэн байх нь зүйтэй.

Уурхайд орж ирэх усыг илээр шүүрүүлэх зумпфийн аргаар зайлуулна. Зумпфийг уурхайн ёроолд байрлуулж зумпфэнд цугларсан усыг гоном ашиглаж зайлуулна. Ил уурхай гүнзгийрэхийн хирээр зумпфийг шилжүүлэн гүний түвшинд байрлуулах, ус шахах хоолойг уртасгах замаар ажиллагааг хангана.

Хүснэгт 17. Насос усны шахуургын үзүүлэлт

Шахуурга	Жин, кг	Шахах өндөр, м	Хүчин чадал, м³/цаг	Эргэлтийн давтамж, мин⁻¹	Хамгийн их сорох гүн, м
Насос	91	35	300	3500	5.0

